



# НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ МОНГОЛ УЛС

---

“ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ТӨСӨЛ

2016-2018



## УДИРТГАЛ


Монгол улс нь төр, засгийн зүгээс иргэд, олон нийтийн тусын тулд ил тод байдлыг хангах, иргэдийг хүчтэй болгох, авлигатай тэмцэх, засаглалыг бэхжүүлэх зорилгоор шинэ технологийг нэвтрүүлж ашиглахад чиглэсэн улс орнуудын сайн дурын олон талт санаачлага болох Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ) –д 2013 онд нэгдэн орсон билээ.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Монгол Улсын НЗТ-ийн асуудлыг хариуцан ажилладаг бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 61 дүгээр захирамжаар НЗТ-ийн Үндэсний Зөвлөлийг яамд, зарим Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулж, 2014-2016 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө /ҮАҮТ/-г боловсруулж, 2014 оны 6-р сарын 16-нд хийсэн анхны хурлаар 3 чиглэлд 35 зорилтод ажил төлөвлөн баталсан юм.

Монгол Улс нь Нээлттэй Засгийн Түншлэлд нэгдэн орж, улмаар өөрийн орны ил тод, нээлттэй байдлын ололт, сургамж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, анхны ҮАҮТ-г төр, иргэний нийгмийн байгууллагуудын өргөн оролцоотойгоор боловсруулж, ҮАҮТ-г хэрэгжүүлэхдээ бүх салбарт мэдээлэл, технологийн дэвшлийг нэвтрүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, олон улсын шилдэг туршлагаас харилцан суралцан ажиллахаар төлөвлөн маш эрчимтэй ажиллаж эхэлсэн нь нэг чухал алхам болсон.

Гэвч анхны ҮАҮТ-г баталснаас хойш хэрэгжүүлэх шатандаа Үндэсний зөвлөл НЗТ-ийн оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжин, үйл ажиллагааны зорилт, чиглэлээр хангаж, хариуцах үүргээ бүрэн биелүүлж ажиллаагүй, түншлэгч талуудын өөрсдийн хүчин чармайлт, оролцоо дутмаг байсан нь төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна гэдгээсээ цаашид бид сургамж авах ёстой.

ҮАҮТ-ний хэрэгжилтийн дунд хугацааны өөрийн үнэлгээний тайлан болон НЗТ-ийн зарчмын дагуу бие даасан шинжээчид хөндлөнгийн үнэлгээг 2015 онд хийж гүйцэтгэсэн болно. Энэхүү төлөвлөгөөнд Монгол улс нь НЗТ-ээс багцлан тодорхойлсон дэлхийн улс, орнуудад тулгарч сорилтуудаас гурвыг нь онцлон үндсэн чиглэлээ болгож, 35 зорилт дэвшүүлэн ажилласнаас хөндлөнгийн үнэлгээгээр 3 зорилтот ажил “од” үнэлгээ авсан байна.



Ийнхүү бид өмнөх 2 жилийн үйл ажиллагаанаас сургамж авч, төлөвлөгөөг боловсруулахаас эхлээд олон нийтийн хэлэлцүүлэгт түншлэгч талуудыг жигд түвшинд, өргөнөөр оролцуулах, тэдний саналыг ҮАҮТ-ндөө дэвшүүлэн тусгаж ажиллахаар зорьлоо.

2016 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан Үндэсний зөвлөлийн хуралдаан, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгээр Нээлттэй засгийн түншлэлийн 2014-2015 оны үйл ажиллагаа, ҮАҮТ-ний хэрэгжилт, тайлан, хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн дүнгийн тухай, болон түүнчлэн, 2016-2018 оны ҮАҮТ-ний төсөл боловсруулах асуудал болон Ажлын хэсгийг байгуулах тухай тус тус ажлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн юм.

Ажлын хэсэгт иргэний нийгмийн туршлагатай төлөөлөл болон сайн дурын үндсэн дээр Засгийн газрын яамдын төлөөллийг оролцуулан, Үндэсний зөвлөлийн дэргэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 65 дугаар тушаалаар 17 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Тус ажлын хэсэг нь өмнөх ҮАҮТ, түүний биелэлт, өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн шинжээчдийн өгсөн дүгнэлт, үнэлгээний мэдээлэл эмх замбараагүй, нэгдсэн дүгнэлт гаргах боломжгүй байна хэмээн үзэж Ажлын хэсэгт зөвлөх ажиллуулахыг эхний хурлаараа тохирсон.

Ажлын хэсгийн зөвлөмж, чиглэлийн дагуу зөвлөхүүд өмнөх төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалт, өөрийн үнэлгээ, хөндлөнгийн тайлан, мэдээллийг нэгтгэн, НЗТ-ийн зарчим, шаардлагад нийцүүлэн, шинээр боловсруулах ҮАҮТ-ний бүтэц, зохион байгуулалтыг ажлын хэсгээр хэлэлцүүлэн батлуулж, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, саналуудыг нэгтгэн, 2016-2018 оны ҮАҮТ-ний төслийг боловсрууллаа.



## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны ҮАҮТ-г дэлхий нийтээрээ тогтвортой хөгжлийн 17 зорилт дэвшүүлэн, түүний хүрээнд Монгол улс нь 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн бодлого, тэргүүлэх зорилтоо тодорхойлон гаргаж байгаатай зэрэгцэн боловсруулж байгаагаараа онцлог юм.


Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно<sup>1</sup> хэмээн зорьж байгаа бөгөөд ийнхүү үндсэн зорилтуудыг дэвшүүлэн үзэл баримтлалаа баталсан энэ цаг үед Монгол улсын Засгийн Газар нь НЗТ-ийн 2 дахь ҮАҮТ-г хэлэлцэн боловсруулж, батлан гаргаж байна.

Монгол улс тогтвортой хөгжлийн зорилтоо тогтвортой засаглалыг хангах замаар хэрэгжүүлэх бөгөөд НЗТ-ийн ил тод, нээлттэй, оролцоотой, хариуцлагатай, мэдээлэл технологийн дэвшлийг ашиглах зарчмуудыг баримтлан төр-хувийн хэвшил, иргэд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, олон улсын байгууллагатай хамтран түншлэн ажилласнаар Засгийн газарт ил тод, нээлттэй, хариуцлагатай, авилгаас ангид байх нөхцөл бүрдэх өндөр ач холбогдолтой юм.

Монгол улс сайн засаглал, эргэн тайлагнах байдлыг сайжруулах чиглэлээр хийж байгаа шинэтгэлүүдийн хүрээнд 2005 оны НҮБ-ын Авлигын эсрэг конвенцэд нэгдэн орж, авлигатай тэмцэх чиглэлээр олон тооны хууль тогтоомжуудын төслийг боловсруулан гаргаж, хараат бус хяналтын механизмыг бий болгож, 2007 онд АТГ-ын үүсгэн байгуулсан. Мөн Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай хууль (2012), Төсвийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014), Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хууль (2014), Захиргааны ерөнхий хууль (2015), Нийтийн сонсголын тухай хууль (2015), Өрийн удирдлагын тухай хууль (2015) зэрэг хуулийг батлан гаргах, Нээлттэй гэрээ, олон улсын төсвийн түншлэл (2005), Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (2006), Нээлттэй Засгийн Түншлэлийн санаачлага (2013) зэрэгт нэгдэн орох, Авлигын эсрэг парламентчидын дэлхийн байгууллагын салбарыг (2012) Монгол улсад байгуулах зэрэг хүчин чармайлтуудыг гаргаж байна.

---

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт, Монгол улсн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал



Хэдийгээр ийнхүү хүчин чармайлтуудыг гаргаж байгаа боловч бодит нөхцөл байдал дээр авлигал ....., хувь хүний хөгжил ....., жендэрийн эрх тэгш байдал ....., ил тод уул уурхай ....., хүний эрхийн байдал ..... байна.

Иймд Монгол улсын Засгийн Газар нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан НЗТ-ийн суурь 5 сорилтын хүрээнд асуудлаа тодорхойлж, тус бүрт нь үндсэн зарчмаа баримтлан, олон улсын бусад баримт бичгээр хүлээсэн үүргүүдтэйгээ уялдуулан, ..... чиглэлээр ..... үүрэгт амлалтууд авч , ажиллахаар төлөвлөлөө.

Монгол улс өмнөх төлөвлөгөөндөө засаглалын 3 сорилтыг онцлон авч үзсэн бол энэ удаад:

1. Төрийн үйлчилгээг сайжруулах
2. Төрийн шударга ёсыг нэмэгдүүлэх
3. Үндэсний баялаг, нөөцийн үр дүнтэй удирдлага
4. Аюулгүй нийгмийг цогцолоох
5. Компаний хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг НЗТ-ээс тодорхойлон гаргасан үндсэн 5 сорилт бүгд тодорхой хэмжээгээр тулгамдаж буй асуудал мөн болохыг ..... удаагийн хэлэлцүүлэг, ..... байгууллага, хүмүүсийн саналаар тодорхойлон гаргаж ирлээ.

Олон талын оролцоог ханган, тэдний түншлэл дээр тулгуурлан тодорхойлсон эдгээр зорилт нэг бүр дээр талууд өөрсдөө хэрхэн хамтран ажиллах саналыг төр, хувийн хэвшил, иргэний нийгэм-иргэд, хэвлэл мэдээлэл, олон улсын байгууллага тус бүрийг оролцуулан авахыг бид хичээлээ.

Учир нь, өмнөх 2014-2016 оны ҮАҮТ-ний зорилтыг дэвшүүлэхдээ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг тавьсан, бусад оролцогч талуудыг дурьдаагүй байсан нь түншлэлийн үндсэн зарчимд нийцээгүй, олон талт оролцоог хангаагүй, улмаар ҮАҮТ-ний хэрэгжилт хангалтгүй байхад сөргөөр нөлөөлсөн гэх мэт сургамжуудыг бид авсан болно.

Монгол Улсын Нээлттэй Засгийн Түншлэлийн 2014-2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр нь 3 чиглэлийн 11 зорилтын хүрээнд 35 үйл ажиллагааг багтаасан байсан.

Анхны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний дүнг нэгтгэн харуулбал:

<b>Тулгамдаж буй чиглэл</b>	- ил тод байдал, иргэдийн оролцоог хангах	Төрийн үйлчилгээг сайжруулах	Шударга ёсыг тогтоох, авилгал бууруулах	
<b>Хийх ажлын хүрээ</b>	Төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх	Төрийн үйлчилгээг сайжруулах	Шударга ёсыг бэхжүүлж, авилгалыг бууруулах	
<b>Зохион байгуулалт</b>	Үндэсний зөвлөл байгуулна, хяналт тавих хөндлөнгийн тогтолцоо бүрдүүлнэ, Санамж бичиг баталгаажуулна, Ажлын алба байгуулна.			
<b>Зорилт</b>	4	4	3	
<b>Үйл ажиллагаа</b>	17	8	5	
<b>Өөрийн үнэлгээ</b>				
<b>Биелэгдсэн</b>	0	0	1	
<b>Хязгаарлагдмал</b>	6	2		
<b>Дөхөж байгаа</b>	4	3	3	
<b>Эхлээгүй</b>	2	1		
<b>Хөндлөнгийн үнэлгээ</b>				
НЗТ	<b>Тодорхой</b>	8	6	4
	<b>Тодорхой бус</b>		1	
Нөлөөлөл	<b>Нөлөө бага</b>	1	1	1
	<b>Дунд нөлөөтэй</b>	2	2	1
	<b>Томоохон нөлөөтэй</b>	5	5	2
Гүйцэтгэл	<b>Эхлээгүй</b>	1	3	2
	<b>Дутуу</b>	4	3	3
	<b>Ихэнх нь</b>	3	1	
	<b>Бүрэн</b>			1



Энэхүү ерөнхий дүнгээс, сорилт бүр дээр тулгарч буй бэрхшээл, түүнийг сайжруулахад төлөвлөсөн үйл ажиллагаа нь эмх замбараагүй, зорилтод асуудлаа хөндөж чадаагүй харагдаж байна. Энэ нь улмаар тулгамдаж буй асуудлаа хэрхэн сайжруулсан талаарх үнэлгээ хийж, нэгдсэн дүгнэлт гаргахад хүндрэл учруулсан байв.

Монгол улсын хувьд, өмнөх ҮАҮТ-г НЗТ-ийн 3 сорилтын хүрээнд авч үзэж, бүхэлдээ нээлттэй засаглалын ил тод байдал, төрийн анхан шатны үйлчилгээний асуудлыг хөндөөгүй нь стратеги төлөвлөлт, хэтийн төсөөлөл гаргаагүйтэй холбоотой байна.

Иймд бид үндэсний хэмжээнд олон салбарт сайн засаглалыг хөгжүүлэх, НЗТ-ийн туршлагаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор 5 сорилт тус бүрийг хамруулан төлөвлөх нь НЗТ-ийн зарчим нэг бүрийг хангах үндэс болно гэж үзлээ. Харин салбар бүрийн тэргүүлэх чиглэлийг тухайн салбартаа олон жилийн туршлага, өндөр мэдлэг хуримтлуулсан, түншлэгч талуудаас бүрдсэн ажлын хэсгийн гишүүд санал оруулж, нийтээр хэлэлцэн НЗТ-ийн шалгуурын дагуу эрэмбэлж гаргасан болно.

2016-2018 оны ҮАҮТ-ний тэргүүн ээлжинд тавих сорилт, түүнийг даван туулах ямар үүрэг амлалт авах боломжтойг түншлэгч талуудын оролцоотойгоор шийдвэрлэх зорилгоор Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, биечлэн болон зайнаас оролцох, саналаа өгөх боломжийг олгосон байна. Хэлэлцүүлгийн дүнд  
.....

Олон нийтээр хүлээн зөвшөөрсөн амлалт үйл ажиллагааны хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дэргэдэх Үндэсний Зөвлөл хангах бөгөөд тус зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт, бүтцийг төлөвлөгөөний дэд хэсэг болгон тусгалаа. Энэхүү Үндэсний зөвлөл нь хэрэгжилтийн үе шатуудад хяналт тавьж, чиглэл өгөх, зохицуулах, биелэлтэнд өөрийн үнэлгээг гарган дүгнэж ажиллах юм.

Одоогоор ирсэн байгаа зорилтод үйл ажиллагаа саналууд:

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ	ТӨРИЙН ШУДАРГА ЁСЫГ НЭМЭГДҮҮЛЭХ	ТӨРИЙН НӨӨЦИЙН ҮР ДҮНТЭЙ УДИРДЛАГА	АЮУЛГҮЙ НИЙГМИЙГ ЦОГЦЛООХ	БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
Эрүүл мэнд, боловсрол, эрүүгийн гэмт хэргийн шүүх, ус, цахилгаан, харилцаа холбоо, болон бусад иргэдэд хүрч буй төрийн үйлчилгээнүүдийг хамрана.	Авилга, төрийн ёс суртахуун, хэм хэмжээ, мэдээллийн нээлттэй байдал, санхүүгийн шинэчлэл, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн эрх чөлөө зэрэг асуудлын хүрээг хамарна.	Төсөв, худалдан авах ажиллагаа, гадаадын тусламж зэрэг асуудлын хүрээг хамарна.	Олон нийтийн аюулгүй байдал, харуул хамгаалалтын салбар, гамшиг, хямралын эсрэг хариу, байгалийн хүчин зүйлс зэрэг асуудлын хүрээг хамарна.	Байгаль орчин, авлигын эсрэг тэмцэх, хэрэглэгчдийг хамгаалах, болон олон нийтийн оролцоо гэх зэрэг асуудлуудад хандах байгууллага-н хариуцлагын асуудлыг хамарна.
11:11 төвийг орон нутаг дэлгэрүүлж, гарсан санал хүсэлтийн үр дүн, иргэдийн үнэлэлт дүгнэлтэд судалгаа хийх	Авлигын үзүүлэлтүүд, төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээг илүү тодорхой загварчлах, эрэмбэлэх, санамсаргүй сонголтын аргаар шалгах	Төсвийн байгууллагын орлого, зарлагын гүйлгээг ил тод болгох босго 5 сая төгрөг байгааг бууруулж, наад зах нь 1 сая төгрөг болгох	Хууль, сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцооны нэгдсэн санг ажиллуулах, системд иргэд нэвтэрч, мэдээлэл өгөх боломжийг бий болгох	Уул уурхайн кадастрын компьютержсэн систем болон байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бүрэн мэдээллээр хангах, түгээх
Хуулийн төслийг судалгаа, үндсэн мэдээлэл, баримт бичгийн хамт <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a> цахим хуудсанд байршуулж, иргэд, бүлгээс санал өгөх, харилцах механизмыг тусгах	Хөрөнгө оруулгын мэдүүлгийн үнэн зөв эсэхийг тогтоох хүчтэй механизм бий болгох, үр дүнтэй хориг арга хэмжээ авах	Шилэн данснii Төрийн болон төсвийн байгууллага, төрийн өмчит компани болон орон нутгийн байгууллагын цэс ижил байгааг өөрчилж салбарын болон нийслэл, дүүрэг ба аймаг сум дүүргийн ангилалтай болгох	Хүүхэд хамгааллын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хүүхдийн эрхийн асуудлаар мэдээлэл, зөвлөмж өгөх, санал хүсэлт гомдол санал хүлээн авах, холбогдох арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлэх	Байгалийн баялаг олборлох салбарт иргэний оролцоо, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх




<p>Боловсролын салбарт нээлттэй хэрэглээ, лицензийг өргөн нэвтрүүлэх</p>	<p>Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг НЗТ-ийн зарчмуудад тулгуурлан батлах</p>	<p>Чингис, Самурай бондын зарцуулалтын мэдээллийг ил тод болгож, иргэд, олон нийт, татвар төлөгчдийн хараа хяналтад оруулж ерийн мэдээллийн системийг ажиллуулах, яам, агентлагууд олон улсын зээл, тусламжийн талаарх мэдээллээ ил тод байлгах</p>	<p>Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх</p>	<p>Хэвлэлийн эрх чөлөөг хангах</p>
<p>Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний талаарх олон нийтэд хүртээмжтэй мэдээллүүдийг нэмэгдүүлж, тэдгээрийг түгээх мэдээллийн сувгуудын тоог нэмэгдүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангах. (Дэлхийн Банкнаас хэрэгжүүлж буй Монгол улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл</p>	<p>Хэвлэлийн эрх чөлөөг хангах</p>	<p>Олон улсын санаачлага болох Нээлттэй гэрээний дата стандартыг худалдан авалтын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх. Энэхүү санаачлага нь Сангийн Яам, Худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлж буй санаачлагатай бүрэн уялдаж байгаа. Мөн энэхүү санаачлагуудыг Дэлхийн Банкны холбогдох төслүүд дэмжинэ.</p>		<p>Төрийн өмчит компаниуд хараат бус ТУЗ-ийн гишүүдтэй байх</p>
<p>Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон хэрэглэгч буюу иргэдийн хооронд харилцан хүндэтгэл, ойлголцол дээр үндэслэсэн бүтээлч болон ажил хэрэгч харилцааг хөгжүүлнэ. (Дэлхийн Банкнаас хэрэгжүүлж буй Монгол улсад Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл /</p>	<p>Нийтийн сонголын тухай хуулийн хэрэгжилтийг хангах</p>	<p>Төсөв санхүүгийн мэдээллийг автоматаар шинэчилж байх</p>		<p>Олборлох лиценз эзэмших компаниуд өөрийн өмч эзэмшлийн тухай болон эздийг мэдээлэх</p>
<p>Боловсролын салбарын зээл, тусламжийн талаарх мэдээллийг илүү нээлттэй, хүртээмжтэй болгох</p>	<p>Байгаль орчны яамнаас агаар, ус, хөрсний бохирдлын түвшний талаарх мэдээллийг нээлттэй байлгах</p>			



Нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар мэдээлэл, зөвлөмж өгөх, санал хүсэлт гомдол санал хүлээн авах, үйлчилгээний стандартыг боловсруулж мөрдүүлэх зэргээр холбогдох арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлэх	Ашигт малтмал, газрын тос, газар, ус зэрэг нийтийн өмчийг ашиглахаар байгуулж байгаа гэрээний ил тод байдлыг хангаж, иргэдэд нээлттэй болгох			
Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг иргэд, даатгуулагчдад таниулах, үйлчилгээний талаарх мэдээллийг түргэн шуурхай хүргэх, иргэдийн санал, гомдлыг хүлээн авч, шуурхай мэдээлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлэх				
Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр инноваци, шинэ техник технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих.				
Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг илэрхийлэх, үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох				

## ХҮЧИН ЧАРМАЙЛТУУД –Амлалт үйл ажиллагаанууд

Сорилт 1.



Өмнөх төлөвлөгөөнөөс ахиц, сургамж

Одоогийн тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, зорилтод ажил, үүнийг хийснээр НЗТ-ийг яаж сайжруулах хүлээгдэж буй үр дүн

**Товчилсон үг, үсгийн жагсаалт**